

**Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг Үндсэн
хуулийн цэц хамгаалах онолын үндэслэл**

**The Theoretical Basis for Protecting Economic, Social,
and Cultural Rights in The Constitutional Tests (Court)**


Тогтохын Эмүжин

Хууль зүйн ухааны бакалавр (LL.B.).

Улаанбаатар хот, Монгол Улс

emvjint232@gmail.com

© T.Emujin, 2025



[Attribution-NonCommercial 4.0 International
\(CC BY-NC 4.0\)](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/)

[Товч утга]

Энэхүү өгүүллээр эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг Үндсэн хуулийн цэц хамгаалах үндэслэлийг улс төрийн философи болон хүний эрхийн онолын үүднээс тоймлон тодорхойлсон. Мөн эдгээр эрхийн хэрэгжилт нь төрийн нөөц, бодлоготой салшгүй холбоотой тул эрх мэдэл хуваарилах зарчмыг зөрчихгүйгээр эрхийг хамгаалахад баримтлах зарчмыг тодорхойлохыг зорьсон болно. ЭЗНСЭ-ийн маргааныг хянан шийдвэрлэхэд ямар зарчмыг удирдлага болгох талаар судлах нь тэдгээр эрхийн хамгааллыг нэмэгдүүлэх, маргааныг шийдвэрлэхэд баримтлах шалгуур, аргачлал илүү тодорхой болох, улмаар Цэцийн шийдвэрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал, иргэдийн Цэцэд итгэх итгэлийг бэхжүүлэх зэрэг ач холбогдолтой. Энэ хүрээнд үндсэн эрхийн цөмийг тогтоох, тэгш байдал, тохирсон байх зарчим зэрэг шалгуурыг онолын түвшинд авч үзсэн. Өөрөөр хэлбэл зөвхөн онолын судалгаа хийн дүгнэлт гаргасан болохыг дурдах нь зүйтэй.

[Түлхүүр үг]

Эдийн засаг, нийгэм, соёлын эрх, Үндсэн хуулийн цэц, эрхийн цөм, тэгш байдал, тохирсон байх зарчим, эрх мэдэл хуваарилалт.

I. Оршил

Монгол Улс 1992 онд анхны ардчилсан Үндсэн хуулиа баталсан. Уг Үндсэн хуулиар төрийн эрх мэдлийг хуваарилж, хяналт, тэнцлийг хангасан бөгөөд үндсэн эрх, эрх чөлөөг баталгаажуулсан. Ингэхдээ иргэний болон улс төрийн эрх (цаашид “ИБУТЭ” гэх), эдийн засаг, нийгэм, соёлын эрх (цаашид “ЭЗНСЭ” гэх)- ийг цогцоор нь нэгэн адил субъектив эрхээр томъёолжээ. Өөрөөр хэлбэл Үндсэн хуульд тусгагдсан хяналтын объектоор үндсэн эрх зөрчигдсөн гэж үзвэл ямар төрлийн эрх байхаас үл хамааран Үндсэн хуулийн цэц (цаашид “Цэц” гэх)-ийн эрх хэмжээний хүрээнд хандах боломжтой. Гэвч ЭЗНСЭ онцлог шинжтэй бөгөөд ихэвчлэн төрийн идэвхтэй үйлдэл, нөөц бололцоо, зохист бодлогыг шаардаж байдаг. Үүнээс улбаалаад Цэцэд ЭЗНСЭ-ийн маргаан үүссэн тохиолдолд төрийн бодлогын оновчтой байдлыг үнэлэх, улмаар эрх мэдэл хуваарилах зарчим хөндөгдөх зэрэг асуудал тулгардаг. Тиймээс уг үндсэн эрхийн маргааныг хянан шийдвэрлэхдээ ямар зарчмыг удирдлага болгох талаар судлах нь ЭЗНСЭ-ийн хамгаалалт нэмэгдэх, уг маргааныг шийдвэрлэхэд баримтлах зарчим, шалгуур тодорхой болох, улмаар Цэцийн шийдвэрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал, иргэдийн итгэл нэмэгдэх зэрэг ач холбогдолтой.

Энэхүү өгүүлэл нь оршил, дүгнэлт болон гурван хэсгээс бүрдэх бөгөөд ЭЗНСЭ-ийн талаарх ойлголт, маргааныг улс төрийн философи болон хүний эрхийн онолын үүднээс тоймлон бичиж, эдгээр эрхийг хэрэгжүүлэхэд шүүхийн үүргийг тодорхойлох нь чухал болохыг авч үзнэ. Түүнчлэн Үндсэн хуулийн шүүх ЭЗНСЭ-ийн маргааныг шийдвэрлэхдээ улс төрийн бодлогыг хүндэтгэж, эрхийн цөмийг үгүйсгэсэн эсэх, тэгш байдлын зарчмыг зөрчөөгүй эсэх, тохирсон байх зарчмыг хангасан эсэхийг шалгах нь зүйтэй талаар дүгнэнэ.

II. ЭЗНСЭ-ийг улс төрийн философийн өнцгөөс авч үзэх нь

Чөлөөт зах зээлийг дэмждэг улс төрийн үзэл суртал ИБУТЭ-ийг чухалчилж, түүнийг хамгаалахаас бусад тохиолдолд төрийн оролцоо бага байх ёстой гэж үзэн ЭЗНСЭ-ийг бүгдэд адил тэнцүү эдлүүлэхийг эсэргүүцдэг. Иймд энэ хэсэгт ЭЗНСЭ-ийг хүлээн зөвшөөрөхтэй холбоотой эсэргүүцлийг хамгийн их илэрхийлэх магадлалтай үзэл суртал тэдгээр эрхийг хэрхэн хүлээн зөвшөөрдөг, үгүйсгэдэг талаар товчхон бичнэ.

Чөлөөт зах зээлийн онолыг дэмждэг үзэл суртлыг либертари, сонгодог либерал, чөлөөт зах зээлийн либерализм, нийтийн сонголтын эдийн засаг, эдийн засгийн либерализм, неолиберализм

гэх мэтээр нэрлэдэг.¹ Тэдний гол төлөөлөгчид нь Ж.Локк, А.Смит, Т.Жефферсон, Ж.Милл, Ф.Хайк, И.Берлин, Р.Нозик нар юм.² Эдгээр эрдэмтэн өөр өөрийн ялгаатай үзэл санааг дэвшүүлдэг хэдий ч зарим байр суурь дээр нэгддэг. Тодруулбал, ихэнх нь хувь хүний эрх чөлөө (individual freedom)-г эрхэмлэдэг бөгөөд хүмүүс өөрсдийн сонголтоор амьдрах, төрийн оролцоо хамгийн бага байх ёстой гэж үздэг.³ Төрөөс хувь хүний эрх чөлөөнд халдаж, албадлага хэрэглэх цорын ганц сайн үндэслэл нь бусдад хохирол учруулахаас сэргийлэх явдал юм.⁴ Хүмүүсийн ялгаатай байдал нь бодит амьдрал дээр үргэлж байсаар ирсэн бөгөөд эдгээр ялгааг арилгах оролдлого нь утопи гэж үздэг.⁵ Социализм болон халамжийн төрийг эсэргүүцдэг учраас позитив эрх чөлөөг мөн няцаах тохиолдол байсан. Гэсэн хэдий ч сүүлийн үед (1) хүмүүс нэг нэгэндээ саад болдоггүй нийгэм, (2) ихэнх хүн өөрсдийн зорилгодоо хүрэх чадвар, хэрэгсэлтэй нийгмийг хүсэж байна гэдэг.⁶ Социализм нь өөрсдийн иргэдэд позитив эрх чөлөө эдлэхэд огт тусалж байгаагүй бөгөөд позитив эрх чөлөөг тууштай баримтлах нь социализмд зөвшөөрөл өгсөн хэрэг биш юм гэв.⁷

“Эдийн засгийн эрх чөлөө нь хүний үндсэн суурь эрх бөгөөд ёс зүйн хувьд үг хэлэх болон оюун санааны эрх чөлөөтэй адил зүйл мөн. Хүн бүр эдийн засгийн багтай бөгөөд өргөн эрх чөлөөтэй. Зах зээл нь ялагч төдийгүй ялагдагчийг ч төрүүлдэг. Тиймээс ядуусыг боломжийн амьдралаар хангахын тулд эдийн засгийн өргөн эрх чөлөөнд хязгаарлалт тавих хэрэгтэй” гэжээ.⁸

Зарим сэтгэгчид радикал байдаг ч тэдний ихэнх нь нийгмийн наад захын хэрэгцээг хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ бүх нийтийн эрх бус зорилгот бүлгийн наад захын эрх гэдгээр хүлээн зөвшөөрсөн.⁹ 20-р зууны либерал философич Ж.Роулс шударга ёсны хоёр зарчмыг тодорхойлсон бөгөөд нэгдүгээр зарчим нь хоёрдугаар зарчмаас давуу эрхтэй гэж үзсэн. Нэгдүгээрт хүн бүр үндсэн эрх чөлөөг (иргэний болон улс төрийн эрх) тэгш эдлэх ёстой. Хоёрдугаарт нийгэм, эдийн засгийн тэгш бус байдал нь (1) албан тушаал, байр суурь хүн бүрд

¹ Michael Freedен, Lyman Tower Sargent, and Marc Stears (Eds.), *The Oxford Handbook of Political Ideologies*. (Oxford: Oxford University Press, 2013), 476 дахь тал.

² Eamonn Butler, *Classical Liberalism: A Primer*, (London: Institute of Economic Affairs, 2015), 99-108 дахь тал.

³ Eamonn Butler, *Өмнөх эшлэл 2*, 3 дахь тал.

⁴ Eamonn Butler, *Өмнөх эшлэл 2*, 6 дахь тал.

⁵ Eamonn Butler, *Өмнөх эшлэл 2*, 7 дахь тал.

⁶ Брэнан Жейсон, *Либертари үзэл*, (Орч. Б. Батчулуун), (Улаанбаатар: Непко, 2013), 55 дахь тал.

⁷ Брэнан Жейсон, *Өмнөх эшлэл 6*, 57 дахь тал.

⁸ Брэнан Жейсон, *Өмнөх эшлэл 6*, 138 дахь тал.

⁹ Michael Freedен, Lyman Tower Sargent, and Marc Stears (Eds.), *Өмнөх эшлэл 1*, 493 дахь тал.

шударга боломжийн тэгш байдлын нөхцөлөөр нээлттэй байх, (2) нийгмийн хамгийн бага давуу талтай (least-advantaged) хүмүүст ашигтай байх нөхцөлийг хангах ёстой гэж үздэг. Шударга боломжийн тэгш байдал нь албан тушаал, байр суурьд формаль утгаараа нээлттэй байхаас гадна түүнд хүрэх шударга боломжийг бий болгохыг шаардана. Шударга боломж гэдэг нь ижил түвшний авьяас, чадвар, хүсэл эрмэлзэлтэй хүмүүс нийгмийн гарал үүсэл, төрж, төлөвшсөн анги давхаргаасаа үл хамааран амжилтад хүрэх ижил боломжтой байхыг хэлнэ. Жишээлбэл нийгэм нь гэр бүлийн орлогоос үл хамааран бүх нийтэд тэгш суурь боловсрол олгох боломжийг бүрдүүлэх ёстой.” гэж үздэг.¹⁰ Өөрөөр хэлбэл нийгэм, эдийн засгийн тэгш бус байдал байх аваас иргэд бололцооны тэгш байдлыг хүртсэний эцэст зарим нь дутуу, зарим нь илүү байранд очсон нь үндэслэлтэй. Мөн ийм тэгш бус байдал цаг хугацааны явцад ядуу хэсэгт ашигтай эргэхээр байх ёстой гэжээ.¹¹ Иймд Ж.Роулс нийгмийн хамгийн бага давуу талтай бүлгүүдийн ЭЗНСЭ-ийн цөмийг баталгаажуулах нь шударга ёсны нэг хэсэг гэж хүлээн зөвшөөрдөг.

Төрөөс хувь хүний эрхэд хязгаарлалт тавих цорын ганц үндэслэл нь бусдад хор хохирол учруулахаас сэргийлэх явдал гэж үздэг¹² Ж.Милл хувь хүн засгийн газрын үйл ажиллагааны зардлыг хуваалцаж, өөрсдийгөө авч явах чадваргүй хүмүүст татвар төлдөг байх ёстой гэж үздэг.¹³ Өөрөөр хэлбэл зах зээлийн эдийн засагт хангагдаж чадаагүй нийтийн сайн сайхныг хангахын тулд татвар хураахыг зөвтгөдөг.

Орчин үеийн либерализм нь хувийн эрх чөлөөг дэмждэг боловч эрх чөлөөг албадлагагүй байдлаас илүү өргөн хүрээнд авч үздэг. Жишээлбэл төр нь хүмүүсийг өмчөөс үүдэлтэй тэгш бус байдлаас хамгаалах ёстой. Ядуу хүмүүст зориулсан халамжийн тогтолцоог (welfare system) бий болгох, ажил олгогчийн эсрэг ажилчдыг хамгаалахыг дэмждэг. Тэд эдийн засгийн эрх чөлөө нь нийтэд ашиг тустай гэдэгт эргэлзэж, төр нь боломжийг нэмэгдүүлэх, зах зээлийг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэхийн тулд оролцох ёстой гэж үзэж байна.¹⁴

Чөлөөт зах зээлийг хэт их тэгш бус байдлыг авчирдаг учраас

¹⁰ John Rawls, *Justice as Fairness: A Restatement*, (Cambridge, MA: Harvard University Press, 2001), 42-44 дэх тал.

¹¹ Адам Свифт, *Улс төрийн философи* (3 дахь хэвлэл), (Орч. Б. Батчулуун), (Улаанбаатар: Эрх зүйт ёс сан, 2016), 40 дэх тал.

¹² Жон Стюарт Милл, *Эрх чөлөөний тухай*, (Орч. Н. Лхагважав), (Улаанбаатар: Монсудар, 2021), 29 дэх тал.

¹³ Жонатан Вольф, *Улс төрийн философи*, (Орч. Б. Батчулуун), (Улаанбаатар: Непко, 2006), 142-143 дахь тал.

¹⁴ Eamonn Butler, *Өмнөх эшлэл 2*, 13 дахь тал.

шударга бус гэх үндэслэлээр шүүмжилдэг¹⁵ бөгөөд амьдралын наад захын хэрэгцээг хангах үүднээс ядуурлын асуудалд төр оролцох, олон нийтэд үзүүлдэг негатив нөлөөллийг багасгаж байж сайжралыг олно.¹⁶ Тиймээс чөлөөт зах зээлийг дэмждэг баруун, зүүн төвийн үзэл суртал төрийн оролцоо хязгаарлагдмал байхыг чухалчилдаг боловч ийм нийгэмд эрх ашиг нь хөндөгдөж байгаа хүнийг хамгаалах үүднээс тодорхой хэмжээнд төр оролцох ёстойг дэмжиж байна. Энэ нь ЭЗНСЭ-ийг хүлээн зөвшөөрдгийн илрэл юм.

Социаль демократ үзэл нь 19-р зууны сүүлээр олон улсын ажилчдын хөдөлгөөнөөс социализмын шинэчлэл болж гарч ирсэн. Анх социализмыг капитализмаар солих зорилготой байсан ч үүний тулд эхлээд капитализмаас өөрөөс нь хамгаалах ёстойг ойлгосон.¹⁷ Өөрөөр хэлбэл *laissez-faire* капитализмын бий болгосон тэгш бус байдал, дарангуйллыг эсэргүүцдэг. ХБНГУ-ын социаль демократ намын гишүүн Бернштейн социаль демократ үзлийг либерализмын өв залгамжлагч гэж үздэг. Либерализм хувь хүний эрх чөлөөг хязгаарлаж буй хуулийн хязгаарлалтын эсрэг тэмцдэг бол социаль демократ үзэл нь хувь хүнийг түүний үйлдэл, ажил мэргэжлийн сонголт дахь эдийн засгийн дарамтаас чөлөөлөхийг эрмэлздэг.¹⁸ Тэд дахин хуваарилалт, боловсрол дахь тэгш бус байдлыг арилгах, ажилчдын дуу хоолойг бэхжүүлэхийг зорьдог.¹⁹

Харин эсрэгээрээ 20-р зууны эрс либертари үзэлтэн болох Р.Нозык хуваарилалтын зүй ёсны (*distributive justice*) тухай онолыг өмчлөх эрхтэй эсэх тухай онол гэж үзээд, өмчийг зүй ёсоор бий болгож, зүй ёсоор шилжүүлсэн бол одоогийн хуваарилалт зүй ёсных гэж үздэг.²⁰ Тиймээс нэгэнт шударгаар бий болсон өмчийг хуваарилах нь шударга бус гэж үзэж, ЭЗНСЭ-ийг үгүйсгэдэг.

Үүнээс дүгнэхэд социализмыг эсэргүүцдэг, хувь хүний негатив эрх чөлөөг чухалчилдаг, төрийн оролцоо бага байх ёстой гэж үздэг баруун, зүүн төвийн үзэл суртал ЭЗНСЭ-ийг хүлээн зөвшөөрч, чөлөөт зах зээлийн сул талыг нөхөх үндэслэлээр тэдгээр эрхийг хэрэгжүүлэхийг дэмждэг байна. Мөн социализмыг эсэргүүцэж, капитализмыг дэмжиж гарч ирсэн социаль демократ үзэл нь

¹⁵ Жонатан Вольф, *өмнөх эшлэл 13*, 161 дэх тал.

¹⁶ Негатив нөлөөлөл гэдэгт агаарын бохирдол, дуу чимээ гэх мэт үйлдвэрээс үүдэлтэй сөрөг хүчин зүйлсийг ойлгоно.

¹⁷ Tony Fitzpatrick, *After the New Social Democracy: Social Welfare for the Twenty-First Century*, (Manchester: Manchester University Press, 2003), 2 дахь тал.

¹⁸ Michael Freeden, Lyman Tower Sargent, and Marc Stears (Eds.), *өмнөх эшлэл 1*, 412 дахь тал.

¹⁹ Michael Freeden, Lyman Tower Sargent, and Marc Stears (Eds.), *өмнөх эшлэл 1*, 421 дэх тал.

²⁰ Брэнан Жейсон, *өмнөх эшлэл 6*, 165-167 дахь тал.

капитализмаас өөрөөс нь иргэдийн ЭЗНСЭ-ийг хамгаалах ёстойг онцолдог. Харин зарим радикал үзэлтэн тус эрхийг үгүйсгэдэг нь цөөн тохиолдол юм. Иймд улс төрийн баруун, зүүн төвийн үзэл суртлын үүднээс тэдгээр эрх тодорхой хэмжээнд хүлээн зөвшөөрөгддөг.

III. ЭЗНСЭ-ийг хүний эрхийн онолын үүднээс авч үзэх нь

Хүний эрх судлаачид 1) ЭЗНСЭ-ийг ИБУТЭ-тэй нэгэн адил хүлээн зөвшөөрөх ёстой; 2) ИБУТЭ нь нэгдүгээр үеийн эрх буюу ЭЗНСЭ-ээс дээгүүр статустай гэсэн 2 ялгаатай байр суурь дээр хуваагддаг. Иймд уг хэсэгт ИБУТЭ-ийг ЭЗНСЭ-ээс давуу гэх үндэслэл болон няцаалтыг бичихийн зэрэгцээ ЭЗНСЭ-ийг ИБУТЭ-тэй нэгэн адил хүлээн зөвшөөрөх ёстой гэх онолын үндэслэлийг авч үзнэ.

Нэгдүгээрт ЭЗНСЭ-ийг хэн хангах вэ²¹, хэрэгжүүлэхэд ямар механизм шаардлагатай вэ, тэдгээр механизмыг дэмжих зардлыг хэн хариуцах вэ²² гэх эсэргүүцэл тулгардаг. Тодруулбал, эдгээр эрхийг хэн, хэрхэн хангахыг нухацтайгаар авч үзэхгүйгээр тунхаглах нь хууль ёсны дагуу хэрэгжих боломжгүйд хүргэнэ гэдэг. Жишээ нь өлсгөлөнд нэрвэгдсэн хүмүүсийг хэн хооллох ёстой байсныг тодорхойлж чадахгүй.²³ Мөн хэрэгжилтийн асуудлыг онцолдог. “Хүний эрх зөвхөн биелүүлж болохуйц ачааллыг л шаарддаг ба ЭЗНСЭ-ийн биелэлтийг тооцоолоход хэцүү. Тиймээс хэрэгжүүлэх институтийн механизмыг шаардана” гэв.²⁴ Эдгээр үндэслэлд өгөх няцаалт нь “олон улсын эрх зүйд ЭЗНСЭ-ийг хангах нь улсын үүрэг” юм.²⁵ Тиймээс ЭЗНСЭ-ийг хэрэгжүүлэх үүрэг хүлээгч нь тухайн улс (төр) бөгөөд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн болон бусад механизмаар дамжуулан хэрэгжүүлэх учиртай.

Хоёрдугаарт ЭЗНСЭ-ийг шүүхээр хамгаалах боломжгүй гэж үздэг. Барууны хэв маягийн ардчилалд эдгээр эрхийн хэрэгжилт баялгийн хуваарилалтын үндсэн асуудалтай холбоотой тул энэ талаар “хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн шийдвэрийг шүүх хянан шалгах нь ардчилсан сонгуулиар байгуулагдсан эдгээр байгууллагын бодлогын үйл ажиллагаанд хууль бусаар халдаж, эрх мэдэл хуваарилах зарчмыг зөрчинө” гэжээ.²⁶ Өөрөөр хэлбэл шүүх

²¹ Onora O'Neill, “The Dark Side of Human Rights”, *International Affairs*, 81 (2), 2005, 427 дахь тал.

²² Kay. Boyle, *Economic and Social Rights Law: Incorporation, Justiciability and Principles of Adjudication* (1st ed.), (London: Routledge, 2020), 5 дахь тал.

²³ Onora O'Neill, *Өмнөх эшлэл 21*, 428 дахь тал.

²⁴ James W. Nickel, “How Human Rights Generate Duties to Protect and Provide”, *Human Rights Quarterly*, 15 (1), 1993, 77 дахь тал.

²⁵ Kay. Boyle, *Өмнөх эшлэл 22*, 5 дахь тал.

²⁶ Ellie Palmer, *Judicial Review, Socio-Economic Rights and the Human Rights Act*, (Oxford: Hart Publishing, 2007), 25 дахь тал.

бодлогын нарийн асуудлыг боловсруулж, зарим чиглэлийг бусдаас нь тэргүүнд тавьж эрэмбэлэх юм бол өөрийн эрх хэмжээнээсээ халина.²⁷ Мөн шүүгч эдийн засаг, нийгмийн асуудлаар шаардлагатай мэдлэг туршлагагүй бөгөөд шийдвэрээс гарах бодлогын үр дагаврыг хариуцах боломжгүй гэжээ.²⁸ ЭЗНСЭ бодлого боловсруулах хүрээнд буюу хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн шийдвэрээр хэрэгжих нь нийтлэг боловч шүүхийн журмаар хамгаалах нөхцөл байдал үүсэх тохиолдол бий. Жишээлбэл хүний эрхийн зарчим нь хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, дэмжих үүргийг төрд хүлээлгэдэг. Хүндэтгэх үүрэг нь төр өөрөө тухайн эрхийг зөрчихгүй байх, хамгаалах үүрэг нь бусад этгээдийн хөндлөнгийн оролцооноос хамгаалах, харин дэмжих үүрэг нь эрхээ эдлэхэд аль болох туслах гэсэн утгыг илэрхийлдэг.²⁹ Хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах үүргээ биелүүлэхэд төсвийн зардал, төсөв хуваарилалттай холбоотой бодлого шаардлагагүй.

Гуравдугаарт олон улсын хүний эрхийн гэрээнд эрхийг тусад нь жагсааснаар ИБУТЭ-ийг нэгдүгээр үеийн эрх, ЭЗНСЭ-ийг хоёрдугаар үеийн эрх гэх ангилал бий болж, нэгийг нь нөгөөгөөс нь давуу эрхтэйгээр ойлгох хандлага үүссэн. Тодруулбал, хүний эрхийн баримт бичигт ЭЗНСЭ-ийг хоёрдугаар үеийн эрхээр тодорхойлсноор зарим судлаачид ЭЗНСЭ нь ИБУТЭ-ээс доогуур статустай гэжээ.³⁰ Уг ангилал нь янз бүрийн нийгэм, соёл, туршлага (барууны, либерал, зөвлөлт, социалист ба гуравдагч)-тай түүхэн холбоотой байдаг бөгөөд ач холбогдолгүй ангилал юм.³¹ Олон улсын гэрээний төсөл боловсруулахад нэг болон хоёрдугаар үеийн эрхийг ялгах болсон шалтгаан нь хүйтэн дайны нөхцөл байдал, тухайлбал хүний эрхийн талбарт зүүний болон барууны үзэл суртлын зөрчилдөөн бий болсонтой холбоотой. Зөвлөлт улсууд ЭЗНСЭ-ийн төлөө тэмцэж, социалист нийгмийн зорилгуудтай холбодог байсан. Нөгөө талаас барууны орнууд ИБУТЭ-ийг чухалчлах нь эрх чөлөө, ардчиллын үндэс мөн гэж байв.³² Гэвч өмнөх хэсэгт дүгнэсэнчлэн улс төрийн ямар үзэл суртлаас үл хамааран ЭЗНСЭ-үүд хүлээн зөвшөөрөгдөх хандлага давамгайл. Түүнчлэн олон улсын пактыг боловсруулж байх үед 2 төрлийн эрхийн хэрэгжилтийн мэтгэлцээн зөвшилцөлд хүрээгүй тул хэрэгжилтийн түвшин, хэрэгжүүлэх арга зэрэг нь тусдаа 2 гэрээг байгуулахыг шаардсан. Өөрөөр хэлбэл янз бүрийн улсын нийгэм,

²⁷ Malcolm Langford, “Domestic Adjudication and Economic, Social and Cultural Rights: A Socio-Legal Review”, *Social Science Research Network*, 2009, 98 дахь тал.

²⁸ Malcolm Langford, өмнөх эшлэл 27; Katharine G. Young, *Constituting Economic and Social Rights*, (Oxford: Oxford University Press, 2012), 165 дахь тал.

²⁹ Ellie Palmer, *өмнөх эшлэл* 26, 22-23 дахь тал.

³⁰ Kay. Boyle, *өмнөх эшлэл* 22, 48 дахь тал.

³¹ Kay. Boyle, *өмнөх эшлэл* 22, 49 дэх тал.

³² Kay. Boyle, *өмнөх эшлэл* 22, 55 дахь тал.

эдийн засгийн хөгжлийн ялгаатай түвшин нь 2 гэрээг санал болгоход нөлөөлсөн.³³ Тиймээс хүний бүх эрхийг нэг гэрээнд багтаагагүй нь эрхийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг ялгаатай авч үзсэнээс бус, түүхэн нөхцөл байдалд хэрэгжилт дээр зөвшилцөл үүсээгүйтэй холбоотой.

Дөрөвдүгээрт зарим судлаачид ЭЗНСЭ-ийг хүний эрх түгээмэл байх шалгуурыг хангадаггүй бөгөөд нэн яаралтай хэрэгжүүлэх шинжгүй гэж үздэг. Жишээлбэл хүний эрх түгээмэл байх ёстой боловч хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, амрах эрх нь бүх нийтийн эрх байх боломжгүй.³⁴ Үүний эсрэг үндэслэл нь ИБУТЭ-үүд ч түгээмэл шинжгүй байж болох бөгөөд зарим ЭЗНСЭ нэн яаралтай хэрэгжүүлэх шинжтэй гэх үндэслэл юм. Жишээлбэл сонгох, сонгогдох эрх бүх нийтийн эрх биш, харин хоол хүнстэй байх, нийгмийн халамж хүртэх буюу эд мөнгөний тусламж авах эрх хойшлуулшгүй, суурь ач холбогдолтой.³⁵

ЭЗНСЭ-ийг ИБУТЭ-ийн нэгэн адил хүлээн зөвшөөрөх өөр нэгэн хүчтэй үндэслэл нь хүний эрхийн хуваагдашгүй байх зарчим юм. Энэхүү зарчим нь эрх бүр нөгөөгийнхөө хэрэгжилтэд нөлөөлж, харилцан хамааралтай байдаг гэх санаан дээр суурилдаг³⁶ бөгөөд хүний бүх эрхийг адил хамгаалах нь зүйтэй.³⁷ Жишээлбэл сонгох эрх наад захын хоол хүнс, боловсролтой байж илүү үр нөлөөтэй хэрэгждэг бол сонгогдох эрх санхүүгийн чадавх, бусдын дэмжлэг, мэдлэг, харилцаа холбоо, чөлөөт цагийг шаарддаг.³⁸ Орон байраар хангагдах эрх нь амьд явах эрхийн үндэс болдог.³⁹ Мөн ИБУТЭ, ЭЗНСЭ-ийн хуваагдашгүй шинж байдал нь нэн яаралтай хэрэгжүүлэх эрхийн агуулгаар тайлбарлагддаг. Тухайлбал, эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь хүнлэг бус, хэрцгий хандлагаас ангид байх эрхтэй; хөдөлмөрлөх эрх нь ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрхтэй; эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орон байр, хоол хүнсээр хангагдах эрх нь амьд явах эрхтэй нэгэн адил нэн яаралтай хэрэгжүүлэх шаардлагатай. Практикт ч үүнийг хүлээн зөвшөөрдгийн нэг жишээ бол амьд явах эрхийн тайлбар юм.

³³ Kay. Boyle, *өмнөх эшлэл* 22, 53-54 дэх тал.

³⁴ Maurice Cranston, "Are There Any Human Rights?", *Daedalus*, 112 (4), 1983, 1-13 дахь тал.

³⁵ Jack Donnelly, *Universal Rights in Theory and Practice* (2nd ed.), (Ithaca, NY: Cornell University Press, 2003).

³⁶ Melissa. Labonte and Kurt. Mills, *Human Rights and Justice: Philosophical, Economic, and Social Perspectives*, (London: Routledge, 2018), 14 дэх тал.

³⁷ Manfred Nowak, *UN Covenant on Civil and Political Rights: CCPR Commentary* (2nd ed.), (Kehl am Rhein: N. P. Engel, 2005), 20 дахь тал.

³⁸ Katharine G. Young, *өмнөх эшлэл* 28, 75 дахь тал.

³⁹ David Bilchitz, *Poverty and Fundamental Rights: The Justification and Enforcement of Socio-Economic Rights*, (Oxford: Oxford University Press, 2007), 187 дахь тал.

Тодруулбал, ИБУТЭТОУП-ын хэрэгжилтэд хяналт тавьдаг хараат бус шинжээчдийн байгууллага буюу НҮБ-ын Хүний эрхийн хороо “амьд явах эрхийг хамгаалахын тулд улс эерэг арга хэмжээ авахыг шаардана. Үүнтэй холбогдуулан Оролцогч улс нялхсын эндэгдлийг бууруулах, дундаж наслалтыг нэмэгдүүлэх, ялангуяа хоол тэжээлийн дутагдал, тахал өвчнийг арилгахын тулд боломжтой бүх арга хэмжээг авах нь зүйтэй.” гэжээ.⁴⁰

ЭЗНСЭ-эд ач холбогдол өгч, хэрэгжүүлэхийг дэмждэг төрөл бүрийн норматив онол байдаг. Үүнд эрх чөлөө, хүний нэр төр (human dignity), хууль дээдлэх ёс, ардчилсан ёс гэх мэт үнэт зүйлс хамаарна. Үндсэн хуулийн бичвэрт тусгагдаагүй тохиолдолд ч суурь зарчмын үүднээс ЭЗНСЭ-ийг хүлээн зөвшөөрч, түүний агуулгыг тайлбарладаг. Энэ нь либерал үндсэн хуульд ёстой нийцдэг.⁴¹ Тиймээс эдгээр үнэт зүйлийн үүднээс ЭЗНСЭ хэрхэн хүлээн зөвшөөрөгддөг талаар товчхон авч үзье.

Эрх чөлөө. Философичид эрх чөлөөний ойлголт дээр санал нэгддэг боловч ухагдахуун дээр санал зөрдөг.⁴² Гэхдээ судалгааны энэ хэсэгт тэдний санал зөрөлдөөний талаар бичих бус, харин эрх чөлөө гэх ойлголтын хүрээнд ЭЗНСЭ-ийг дэмжих ухагдахууныг илэрхийлдэг философийн үндэслэлийг авч үзлээ. Жэральд МакКалум эрх чөлөөг Х нь Z-ийг хийхдээ Y-ээс хараат бус байна гэж илэрхийлсэн. Үүний Х-эрх чөлөөний субъект, Y-саад, бэрхшээл, хөндлөнгийн хүчин зүйл, Z-зорилго.⁴³ Харин Адам Свифт МакКалумыг дэмжихийн зэрэгцээ эрх чөлөөг формаль болон үр дүнт гэж ангилсан. Жишээлбэл хэн нэгэн өвчний улмаас хүссэн ажлаа хийх боломжгүй болсон гэж төсөөлье. Хэрэв эрх чөлөө гэдэгт зөвхөн бусдын хөндлөнгийн оролцоогүй байдлыг (формаль эрх чөлөө) ойлгох юм бол тэр хүн эрх чөлөөтэй. Гэвч түүнд хүссэн ажлаа хийх үр дүнт чадвар (эрүүл мэнд) алга. Тиймээс төр зарим иргэдийн үр дүнт эрх чөлөөний (энэ тохиолдолд эрүүл мэндийн үйлчилгээ) баталгаа болно. Энд МакКалумын томъёоллоор Y нь өвчин болж байна.⁴⁴ Үүнээс харахад эрх чөлөө гэх үнэт зүйлийн агуулгад хэн нэгний хөндлөнгийн оролцоогүй байхыг ойлгохоос гадна эрх чөлөөгөө эдлэх боломж бүрдүүлэхийг ойлгохоор байна. Энэ нь ЭЗНСЭ-ийг дэмждэг.

⁴⁰ Human Rights Committee, *CCPR General Comment No. 6: Article 6 (Right to Life)*, (1982), Section 5.

⁴¹ Кау. Boyle, *өмнөх эшлэл 22*, 9 дэх тал.

⁴² Ойлголт гэдэг бол ерөнхий бүтэц, зүй ёс, эрх чөлөө, тэгш ёс зэрэгтэй адил бүтцийг бүрдүүлэгч элемент, харин ухагдахуун бол ойлголтыг нарийвчлан авч үзэж тусгайлсан хэрэг юм. Адам Свифт, *өмнөх эшлэл 11-ээс* харна уу.

⁴³ Адам Свифт, *өмнөх эшлэл 11*, 75 дахь тал.

⁴⁴ Адам Свифт, *өмнөх эшлэл 11*, 81 дэх тал.

Хүний нэр төр. Хүний нэр төрийн үүднээс “амьд явах гэдэг нь зүгээр л оршин тогтнох бус, харин хүний хувьд нэр төртэй амьдрах” гэх ухагдахуун дээр үндэслэж ЭЗНСЭ-ийг тайлбарладаг.⁴⁵ Хүний нэр төр нь эрх чөлөө, амьд явах эрх гэх мэт үнэт зүйлтэй нэгдсэнээр эд мөнгөний тусламж авах, сурч боловсрох субъектив эрхийг үүсгэдэг.⁴⁶ Гэхдээ хүний нэр төрийн ухагдахуун хэрхэн тайлбарлагдах нь тухайн улсын үндсэн хуулийн соёлтой холбоотой. Тодруулбал, төрийн үйлдэл хүний нэр төрд халдсан шинжтэй байвал тухайн үндсэн хуулийн соёлд тусгагдсан зорилготой нийцэж байгаа тохиолдолд л зөвтгөгддөг.⁴⁷ Хэрэв бид хэт их дахин хуваарилалт болон хангалтгүй дахин хуваарилалтыг үндэслэлтэй эсэх шалгуураар шүүвэл үндсэн хуулийн ямар соёлтойгоос шалтгаалаад өөр дүгнэлт гарах боломжтой. Жишээлбэл арьс өнгөөр ялгаварлах үзэлтэй байсан (post-apartheid) Өмнөд Африк болон эдийн засагт төр оролцохгүй байх (laissez-faire) үндсэн хуулийн соёлтой АНУ-д хүний нэр төрд халдахад юуг үндэслэлтэй гэж үзэх нь ялгаатай.⁴⁸

Хууль дээдлэх ёс. Хууль дээдлэх ёсны үзэл санаа Баруун Европт XVIII зуунд хэмжээгүй эрхт хаант ёсны эсрэг тэмцлийн нэг уриа болон гарч ирсэн.⁴⁹ Энэ талаар эрдэмтэд, олон нийтийн дунд өргөн хүрээний маргаан, хэлэлцүүлэг өрнөдөг. Гэсэн хэдий ч хууль дээдлэх ёс нь ардчилал, шударга ёс, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах тогтолцоонд чухал байр суурь эзэлдэг бөгөөд эдийн засаг, улс төрийн хөгжлийн суурь болдог. Хуулийг дээдэлдэг буюу хуулийн засаглалыг бий болгох нь иргэний дайн, дарангуйллын дэглэмд байсан улсын хувьд сэргээн босгох гол алхам байдаг.⁵⁰ Түүхийн явцад хуулиар шударга бус байдлыг тогтоож байсан тохиолдол цөөнгүй байсан. Тиймээс хууль дээдлэх ёсны үндсэн шинжийг хангасан хуулийг л дээдлэх нь зүйтэй гэж үздэг. Ийм үндсэн шинжийн талаар эрдэмтэд янз бүрийн байр суурь илэрхийлдэг боловч сүүлийн үеийн судлаачид хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан хуулийг дээдлэх дээр санал нэгдэж байна.⁵¹ Тиймээс ЭЗНСЭ-ийн хөгжлийг удаашруулдаг дарангуй дэглэмийг эсэргүүцэж,

⁴⁵ Katharine G. Young, *өмнөх эшлэл* 28, 110 дахь тал.

⁴⁶ Robert Alexy, *A Theory of Constitutional Rights*, (Trans. Julian Rivers), (Oxford: Oxford University Press, 2002), 290–93 дахь тал.

⁴⁷ Frank I. Michelman, “Reasonable Umbrage: Race and Constitutional Antidiscrimination Law in the United States and South Africa”, *Harvard Law Review*, 117 (5), 2004.

⁴⁸ Frank I. Michelman, *өмнөх эшлэл* 47.

⁴⁹ Бяраагийн Чимид, *Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс: Ихэс дээдэс, хүн бүрт хандсан дөрвөн өчил*, (Улаанбаатар: 2006), 124 дэх тал.

⁵⁰ Gerald J. Postema, *The Idea of the Rule of Law in Law’s Rule*, (Oxford: Oxford University Press, 2022), 17 дахь тал.

⁵¹ Тогтохын Эмүжин, *Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс: Үндсэн хуулийн цэцийн эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн баталгааг хангах чиг үүрэг, цар хүрээ*, (Улаанбаатар: 2025).

эрх мэдлийг хязгаарлаж, эрхийг баталгаажуулсан хуулийг дээдлэх нь зүйтэй бөгөөд хууль дээдлэх ёсны агуулга тэдгээр эрхийг дэмждэг.

Ардчилсан ёс. Ардчилал нь шийдвэр гаргах эрх мэдэл бүхий олонхоос цөөнхийн эрхийг хүндэтгэж, өөрсдийгөө хязгаарлахыг шаарддаг.⁵² Үүний нэг бодит жишээ бол олонхын ноёрхлыг хязгаарлаж, цөөнхийн эрхийг хамгаалах талаар үндсэн хуульд заасан байдаг. Өөрөөр хэлбэл иргэний эрхийг үндсэн хуульд тусгаж, түүнийг хамгаалах үндсэн хуулийн хамгаалагчийг байгуулдаг. Энэ үед олонх ямар ч шийдвэр гаргасан бай цөөнхийн эрхийг зөрчихгүй гэсэн баталгаа бий болдог.⁵³ Тиймээс олонхын ардчилсан тогтолцоонд эрхийн оршин тогтнолын шалтгаан нь цөөнхийн эрх юм.⁵⁴ ЭЗНСЭ-ийн нэг болох эд, мөнгөний тусламж авах эрх нь цөөнхийн эрхийг хамгаалах хэлбэр болдог. Учир нь нийгэмд халамж хүртэх шаардлагатай иргэд олонх болдоггүй. Эдийн засгийн хүндрэлтэй үед хамгийн хүнд ачааг улс төрийн хамгийн бага эрх мэдэлтэй ядуу, маргинал бүлгүүд үүрэх магадлалтай тул олонхын эсрэг (counter-majoritarian) зарчим чухал ач холбогдолтой.⁵⁵ Тиймээс ЭЗНСЭ-ийн цөмийг үгүйсгэхгүй (minimum core) байх хэрэгтэй бөгөөд ЭЗНСЭ-ийн хэрэгжилтийг үл тоомсорлох нь ардчиллын эсрэг ухралт юм. ЭЗНСЭ-ийн цөм гэдэг нь үндсэн хуулиар болон нэгдэн орсон олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ эдийн засгийн нөөц бололцоо, бусад нөхцөл байдлаас үл хамааран зайлшгүй хэрэгжүүлэх ёстой эрхийн хамгийн наад захын хэрэгжилтийг илэрхийлнэ. Жишээлбэл Монгол Улсын Үндсэн хуулийн 16.7-д “сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно.” гэж заасан. Энэ хүрээнд бүх нийтийн ерөнхий боловсролын сургуулийг бий болгож, төлбөргүй сургах боломжоор хангах нь сурч боловсрох эрхийн цөм юм.

Иймд үндсэн хууль ардчиллын суурь зарчмын үүднээс ЭЗНСЭ хүлээн зөвшөөрөгддөг. Гэхдээ эдгээр үнэт зүйл нь зарим хүний хувьд ЭЗНСЭ-ийн цөмийг тодорхойлж, эрхийн хэрэгжилтийг дэмжих арга хэмжээ авах боломжийг олгодог⁵⁶ боловч ЭЗНСЭ бүрд ялгаатай тайлбарыг өгөх боломжтой.

Дээрхээс дүгнэхэд улс төрийн философийн ялгаатай үзэл суртал болон хүний эрхийн онолын голлох чиглэл нь ЭЗНСЭ-ийг ИБУТЭ-ийн нэгэн адил хүлээн зөвшөөрөх чиг хандлагатай байна. Гэхдээ тэдгээр

⁵² Девид Миллер, *Улс төрийн гүн ухаан (Товч танилцуулга)*, (Орч. О.Очиржав), (Улаанбаатар: Эрх зүйт ёс сан, 2017), 60 дахь тал.

⁵³ Девид Миллер, *өмнөх эшлэл* 52, 56 дахь тал.

⁵⁴ Eyal Benvenisti, “Margin of Appreciation, Consensus, and Universal Standards”, *International Law and Politics*, 31, 2000, 850 дахь тал.

⁵⁵ Кау. Boyle, *өмнөх эшлэл* 22, 147 дахь тал.

⁵⁶ Katharine G. Young, *өмнөх эшлэл* 28, 119 дэх тал.

эрхийг хэрэгжүүлэхэд төр ямар үүрэгтэй, ямар түвшинд эрхийг хэрэгжүүлэх ёстой, эрхийн цөм гэдэгт юуг ойлгох зэрэг асуултад хариулт өгдөггүй. Тиймээс ЭЗНСЭ-ийн хэрэгжилтийг институтийн өнцгөөс харах үндэслэл бий болж, шүүх хэрхэн хамгаалах ёстой талаар онолын хөгжүүлэлт хийгдэж байна. Иймд дараагийн хэсэгт ЭЗНСЭ-ийг шүүхээр хэрхэн хамгаалах нь зүйтэй талаар буюу ЭЗНСЭ-ийн маргааныг Үндсэн хуулийн шүүх шийдвэрлэхэд баримтлах зарчмыг авч үзнэ.

IV. ЭЗНСЭ-ийн маргааныг шийдвэрлэхэд баримтлах зарчим

ЭЗНСЭ-ийн хэрэгжилт нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн шийдвэрээс хамаардаг учраас шүүхийн журмаар хамгаалах тухайд маргаантай байдаг. Гэхдээ өнөө үед эрхийн негатив болон позитив ангиллаас өөр шинэ ангилал бий болж, эрхийн агуулгын талаарх ойлголт хөгжихийн хэрээр хэрэгжүүлэх арга хэрэгсэл нь өргөн хүрээтэй болсон. Тиймээс эрх мэдэл хуваарилах зарчмыг хөндөхгүйгээр ЭЗНСЭ-ийг шүүх хамгаалах боломжтой талаар хэлэлцүүлэг өрнөж байна.⁵⁷ ЭЗНСЭ-ийг шүүхээр хянагдах эрх (justiciable right), эрмэлзлийн эрх (aspirational right) гэж ангилж⁵⁸, эхний ангилалд хамаарсан тохиолдолд шүүхийн журмаар хамгаална гэж үздэг. Үүнээс улбаатай ЭЗНСЭ ямар тохиолдолд шүүхээр хянагдах эрхэд хамаарах, шүүх ямар зарчмыг удирдлага болгон маргааныг хянан шийдвэрлэх нь зүйтэй вэ гэх асуудал урган гардаг.

Үндсэн хуулиар баталгаажсан ихэнх эрх туйлын биш тул үндсэн эрх хязгаарлагдах боломжтой. Ялангуяа ЭЗНСЭ уян хатан, зааварчилгаа төдий, эсвэл хангалтгүй хэрэгждэг байж болно. Үндсэн хуулийн эрх зүй өөрөө тэдгээр эрхийн хязгаарлалтыг агуулдаг.⁵⁹ Тухайлбал төр эрхийг дэмжих үүргээ биелүүлэхийн тулд эдийн засгийн нөөц зайлшгүй шаардлагатай болно. Тиймээс эдийн засгийн нөөцийн хангалтгүй байдлаас үүдэлтэй тус эрхийн хязгаарлалт хүлээн зөвшөөрөгддөг. Гэсэн хэдий ч төрөөс эрхийн цөмийг үгүйсгэхгүй байх ёстой. Мөн ЭЗНСЭ-ийн хязгаарлалт нь ихэвчлэн төрийн дэмжих үүрэгтэй холбоотой байдаг боловч хүндэтгэх, хамгаалах үүргээ биелүүлэхгүйгээр эрхийн хязгаарлалт бий болох тохиолдол цөөнгүй. Түүнчлэн тодорхой төрлийн ЭЗНСЭ-ийг хэрэгжүүлэхгүй талаар Үндсэн хуульд тусгах эсвэл олон улсын гэрээнд нэгдэн орохдоо мэдэгдэл хийх (reservation), үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр ЭЗНСЭ-ээс ухрах, ЭЗНСЭ-ийг үндсэн хуульд

⁵⁷ International Commission of Jurists, *Judicial Enforcement of Economic, Social and Cultural Rights*, (Geneva: International Commission of Jurists, 2014), 36 дахь тал.

⁵⁸ <https://www.tiesr.org/advisory-board>, (Сүүлд үзсэн: 2023.01.25).

⁵⁹ Katharine G. Young, *өмнөх эшилэл 28*, 186 дахь тал.

төрийн бодлогын зорилго, зарчмын агуулгаар тусгах зэрэг хэлбэрээр хязгаарлах боломжтой. Иймд судалгааны энэ хэсэгт ЭЗНСЭ-ийн маргааныг шийдвэрлэхэд баримтлах эрхийн цөмийг үгүйсгээгүй байх, тэгш байдлын, тохирсон байх, үндэслэлтэй байх, эрх зүйн тодорхой байдлын зарчмыг тодорхойлно. Үүний дараа уг эрхийн хязгаарлалтын төрөл тус бүрийг танилцуулж, удирдлага болгох зарчмыг бичнэ.

Үндсэн хуулийн шүүхийн ЭЗНСЭ-ийн маргааныг хянан шийдвэрлэх эрх хэмжээ нь иргэдээс сонгогдсон төлөөлөгчдийн бодлого тодорхойлох, хууль батлах эрх мэдлээр хязгаарлагдана. Тиймээс ЭЗНСЭ-ийн цөмд төвлөрснөөр Үндсэн хуулийн шүүх нь эрх мэдэл хуваарилах зарчмыг хөндөхгүйгээр тэдгээр эрхийг хамгаалах боломжтой. Өөрөөр хэлбэл ЭЗНСЭ нь ноцтой хөндөгдсөн эсхүл төр негатив үүргээ зөрчсөн тохиолдолд л хянан шийдвэрлэх юм.⁶⁰ Гэхдээ аливаа эрхийн цөм нь тухайн тохиолдлоос хамаарах бөгөөд тодорхой тайлбарлагдаагүй байдаг.⁶¹ Шүүх маргааныг шийдэхдээ эрхээр төсөөлөх үр дүнгээс илүүтэй эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үүрэгт анхаарах нь эрхийг хамгаалах бодитой арга замыг олоход тусална.⁶² Эрхийн цөмийг тодорхойлохдоо олон улсын гэрээ, түүний тайлбар, бусад баримт бичигт тусгасан агуулгыг судлах нь чухал байдаг.⁶³ Жишээлбэл ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийн цөм нь ялгаварлан гадуурхахгүй байх үүрэгтэй холбоотой.⁶⁴ Мөн ЭЗНСЭ-ийн талаарх дотоодын эрх зүй, бүс нутгийн болон харьцуулсан эрх зүйн хөгжилд бий болсон эрхийн цөмийг илрүүлэх аргаар тодорхойлж болно.⁶⁵

Тэгш байдал, ялгаварлан гадуурхахгүй байх зарчим нь ЭЗНСЭ-ийг шүүхээр шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой. Ихэнх ЭЗНСЭ-ийн зөрчил нь тэгш бус байдалтай холбоотойгоор үүсдэг. Тиймээс ЭЗНСЭ-ийг үндсэн хуульдаа тусгаагүй улсад эмзэг бүлгийн хүн эрхээ хэрэгжүүлэхэд тэгш байдал чухал хэрэгсэл болдог.⁶⁶ Бодлого тодорхойлох салбарт ЭЗНСЭ-ийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх үүрэг хүлээлгэдэггүй ч тэдгээр эрхийг дэвшилттэйгээр хэрэгжүүлэхдээ ялгаварлан гадуурхахгүй байх үүргийг хүлээнэ. Иймд Үндсэн хуулийн шүүхээс ЭЗНСЭ-ийн хязгаарлалт бүр дээр удирдлага болгох зарчмын нэг нь тэгш байдлын зарчим байдаг.

⁶⁰ Katharine G. Young, *өмнөх эшлэл 28*, 162 дахь тал.

⁶¹ Katharine G. Young, *өмнөх эшлэл 28*, 171 дэх тал.

⁶² Katharine G. Young, *өмнөх эшлэл 28*, 152 дахь тал.

⁶³ Katharine G. Young, *өмнөх эшлэл 28*, 159 дэх тал.

⁶⁴ Katharine G. Young, *өмнөх эшлэл 28*, 156 дахь тал.

⁶⁵ Katharine G. Young, *өмнөх эшлэл 28*, 159 дэх тал.

⁶⁶ Aoife Nolan, Bruce Porter, and Malcolm Langford, *The Justiciability of Social and Economic Rights: An Updated Appraisal*, (CHRGJ Working Paper No. 15), 2009, 27 дахь тал.

Тохирсон байх зарчим (proportionality test) нь үндсэн эрхийн маргаанд нийтлэг хэрэглэгддэг зарчим юм. Энэхүү зарчмын эхний алхам нь тухайн үйлдэл эрхийн хамрах хүрээг зөрчсөн эсэхийг тодорхойлох. Хэрэв тийм бол эрх нь анхдагч байдлаар (prima facie) зөрчигдсөн болно. Хоёр дахь алхамд эрхийн зөрчлийг зөвтгөх үндэслэл байгаа эсэхийг шалгана.⁶⁷ Гуравдугаарт, зөрчилдөж байгаа эрх, ашиг сонирхлууд нь уялдаатай (suitable), эрхийн хязгаарлалт нь зайлшгүй шаардлагатай (necessary), тэнцвэртэй (proportionality in narrow sense) эсэхийг шалгана. Уялдаатай байх шалгуур нь нэг эрхэд хөндлөнгөөс оролцсоноор нөгөө эрх, ашиг сонирхлыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулсан байхыг илэрхийлдэг.⁶⁸ Зайлшгүй байх шалгуур нь ижил үр дүнд хүрэхийн тулд өөр илүү бага хязгаарласан аргагүй байхыг шаарддаг. Харин тэнцвэртэй байх шалгуур нь тодорхой тохиолдолд өрсөлдөх эрх, ашиг сонирхлуудын жинг харьцуулахыг шаарддаг бөгөөд хязгаарлалт хууль ёсны эсэхийг тодорхойлно.⁶⁹

Үндэслэлтэй байх зарчим (reasonable test) нь төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж буй байгууллага дур мэдэн шийдвэр гаргах бус, хариуцлагатай, үр дүнтэй байх ёстой гэсэн үндсэн хуулийн шаардлагатай нийцдэг. Уг зарчмыг ашигласнаар хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн төрийн бодлогод юуг зохист гэж үзэх эрх хэмжээнд саад болохгүй⁷⁰ бөгөөд зөвхөн эс үйлдэхүйгээр үүргээ биелүүлэхгүй байх, дур мэдэн бодлого тодорхойлж буй эсэхийг л шүүх хянах юм. Иймд шүүх шинжээчийн гаргаж өгсөн нотлох баримт эсвэл бусад эрх мэдлийн тайлбарыг ашиглаж⁷¹ үндэслэлийг шалгах бөгөөд үндэслэлтэй тохиолдолд ЭЗНСЭ-ийн зөрчил үүсээгүй болно.

Эрх зүйн тодорхой байдлын зарчим (legal certainty) нь хууль дээдлэх ёсны хэлбэрийн үзэл баримтлалаар тодорхойлогддог бөгөөд хуулийн дагуу амьдралаа төлөвлөх боломжийг олгох замаар хүний нэр төр болон бие даасан байдлыг хүндэлдэг.⁷² Иргэдийн хувьд хуулийн хэм хэмжээ тодорхой байвал өөрсдийн эрхээ хамгаалж чадна. Хууль тодорхойгүй, ойлгомжгүй байх тусмаа хуулийн хэрэгжүүлэгч болох гүйцэтгэх эрх мэдэл хуулийг өөрийнхөөрөө тайлбарлах боломж олгоно.⁷³ Тиймээс уг зарчим нь хууль тодорхой бус байснаар үндсэн

⁶⁷ Katharine G. Young, *өмнөх эшлэл 28*, 221 дэх тал.

⁶⁸ Kai Möller, “Balancing and the Structure of Constitutional Rights”, *International Journal of Constitutional Law*, 5 (3), 2007, 455 дахь тал.

⁶⁹ Katharine G. Young, *өмнөх эшлэл 28*, 222 дахь тал.

⁷⁰ Katharine G. Young, *өмнөх эшлэл 28*, 216 дахь тал.

⁷¹ Katharine G. Young, *өмнөх эшлэл 28*, 219 дэх тал.

⁷² Одонхүүгийн Мөнхсайхан, *Үндсэн хуулийн хяналт ба тайлбар: үндсэн эрх*, (Улаанбаатар: 2022), 15 дахь тал.

⁷³ Дашбалбарын Гангабаатар, *Үндсэн хуулийн эрх зүйн удиртгал*, (Улаанбаатар: 2012), 95-96 дахь тал.

эрхийг зөрчих нөхцлийг бүрдүүлсэн эсэх, төрийн байгууллага, албан тушаалтан хуулиар олгогдсон эрхээ дур мэдэн хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн эсэхийг үнэлхийг шаарддаг. Ингэснээр үндсэн эрхийн зөрчлийг шалгахад илүү дөхөм болдог.

ЭЗНСЭ-ийг дэвшилттэйгээр хэрэгжүүлэх (progressive realization) үүргээ биелүүлэхгүй байх хэлбэрээр эрхийн хязгаарлалт бий болдог. ЭЗНСЭ ерөнхийдөө дэвшилттэйгээр хэрэгжүүлэх үүргээр хязгаарлагддаг бөгөөд төрийн үүрэгт харьцангуй сул стандартыг бий болгодог.⁷⁴ Жишээлбэл Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (цаашид “ЭЗНСЭТОУП” гэх)-ын 2.1-д “Энэхүү Пактад оролцогч улс бүр дангаараа болон олон улсын тусламж, хамтын ажиллагаагаар, тухайлбал эдийн засаг, техникийн салбарт, энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг бүрэн хэрэгжүүлэхийг дэвшилттэйгээр хангахын тулд хууль тогтоомжийн арга хэмжээг оролцуулан, зохистой арга хэмжээг байгаа бүх боломжийнхоо хэрээр авах үүрэгтэй.” гэж заасан. Уг заалтын талаар НҮБ-ийн Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос “Эдийн засаг, нийгэм, соёлын бүхий л эрхийг богино хугацаанд бүрэн хэрэгжүүлэх нь боломжгүй гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Төрийн хүндэтгэж, хангах шууд үүргийг тусгасан эрхээс ялгаатай юм. Оролцогч улсуудад эрхийн цөмийг үгүйсгэхгүй байхыг үүрэг болгосон. Гэхдээ тухайн улсын эдийн засгийн нөөцийг харгалзан үзэх хэрэгтэй.” гэж тайлбарласан байдаг.⁷⁵ Тиймээс ЭЗНСЭ-ийг дэвшилттэйгээр хэрэгжүүлэх үүрэг нь бүх эрхийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхийг шаарддаггүй боловч эрхийн цөмийг үгүйсгэхгүй байх үүргийг шаарддаг. Иймд төрөөс ЭЗНСЭ-ийг дэвшилттэйгээр хэрэгжүүлэх буюу позитив үүргээ зөрчсөнтэй холбоотой маргаанд эрхийн цөмийг үгүйсгээгүй байх, тэгш байдлын зарчмыг удирдлага болгож шалгах нь зүйтэй.

Төрөөс ЭЗНСЭ-ээ эдлэхгүй байгаа хувь хүн, бүлгүүдийн эсрэг ухрах арга хэмжээ авах хэлбэрээр эрхийн хязгаарлалт үүсдэг. Ухрах арга хэмжээ гэдэгт өмнө нь тогтсон эрхийн хэрэгжилтийг бууруулах төрийн бодлогыг ойлгоно. Жишээлбэл хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг бууруулах, боловсрол, эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг танах, хөдөлмөрийн хууль тогтоомжоор ажилтаны эрхийн хамгаалалтыг багасгах зэрэг юм. Энэ тохиолдолд тохирсон байх зарчмыг хэрэглэнэ.

ЭЗНСЭ-ийн хэрэгжилтийг удаашруулж байгаа тохиолдолд үндэслэлтэй байх зарчим (reasonable test)-ыг хэрэглэнэ. Эрхийн хэрэгжилтийг удаашруулах гэдэгт тодорхой нэг болон хэд хэдэн

⁷⁴ Katharine G. Young, *өмнөх эшлэл* 28, 189 дэх тал.

⁷⁵ UN Committee on Economic, Social and Cultural Rights, *General Comment No. 3: The Nature of States Parties' Obligations*, (Art. 2, Para. 1, of the Covenant)..

эрхийн хэрэгжилтийг хойшлуулах, цаг тухайд нь хэрэгжүүлэхгүй байхыг ойлгоно. Жишээлбэл төрөөс бүх нийтийн суурь боловсролыг үнэ төлбөргүй олгоно гэсэн боловч хангалттай хэмжээний сургууль барихгүй байх, багш нарын мэдлэг, чадварыг дээшлүүлэх бодлого огт хэрэгжүүлэхгүй байх юм.

Төрөөс ЭЗНСЭ-ийн негатив үүргээ биелүүлэхгүй байх хэлбэрээр эрхийг хязгаарладаг. Тодруулбал, ЭЗНСЭ нь төрд хүндэтгэх, хамгаалах негатив үүргийг хүлээлгэдэг. Хүндэтгэх үүрэг нь төр өөрөө эрхэд хөндлөнгөөс оролцохгүй байх, харин хамгаалах үүрэг нь бусдын хөндлөнгийн оролцооноос хамгаалах агуулгыг илэрхийлдэг. Төрөөс уг үүргээ биелүүлэхгүй байх хэлбэрээр ЭЗНСЭ-ийг хязгаарлах тохиолдол цөөнгүй. Энэхүү хязгаарлалт нь ердийн эсхүл онц байдлын үед үүсэж болно. Жишээлбэл ердийн үед албадан нүүлгэх, газар чөлөөлөх арга хэмжээ авч өмчлөх эрхийг хязгаарлах, эсхүл цар тахлын үед (онц байдлын үед) боловсролын байгууллагын үйл ажиллагааг зогсоож, сурч боловсрох эрхийг хязгаарлах тохиолдлыг дурдаж болох юм. Тиймээс ердийн үеийн ЭЗНСЭ-ийн хязгаарлалттай холбоотой маргааныг хянан шийдвэрлэхдээ эрхийн мөн чанар, хязгаарлалтын зорилго, хязгаарлалтын мөн чанар, цар хүрээ, хязгаарлалт болон зорилгын хоорондын уялдаа, зорилгодоо хүрэх илүү бага хязгаарлалттай арга хэрэгсэл байгаа эсэх⁷⁶ буюу тохирсон байх зарчим, эрх зүйн тодорхой байдлын зарчмаар шалгана. Харин онц байдлын үеийн хязгаарлалттай холбоотой маргаан хянан шийдвэрлэхдээ тохирсон байх зарчим⁷⁷, тэгш байдлын зарчмыг хэрэглэнэ. Мөн эрхийн хязгаарлалт урт хугацааны туршид үргэлжлэх үед эрх зүйн тодорхой байдлын зарчмыг шалгах нь зохистой.⁷⁸

ЭЗНСЭ-ийн хэрэгжилтийг баталгаажуулахгүй талаар Үндсэн хуульдаа тусгах эсвэл олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орохдоо тодорхой төрлийн ЭЗНСЭ-ийн хэрэгжилтийг хүлээн зөвшөөрөхгүй талаар мэдэгдэл хийх замаар тус эрхийн хязгаарлалт үүсэх боломжтой. Жишээлбэл Канадын дүрмийн дагуу парламент зарим эрхээс (эрхийн тухай шүүхээр тайлбарласан тайлбарыг оруулаад) татгалзах боломжтой. Дүрэмд зааснаар ардчилсан эрх, зорчих эрх, хэлний эрх зэрэг тодорхой эрхэд татгалзах боломж хамаарахгүй. Канад дахь татгалзах заалт нь парламентын бүрэн эрхт байдлыг хадгалах, улмаар шүүх эрх мэдлийн хууль тогтоомжийг хүчингүй болгох эрх хэмжээг бууруулах зорилготой.⁷⁹ Иймд ЭЗНСЭ-ийн маргааныг шийдвэрлэхдээ Үндсэн хуульд ЭЗНСЭ-ийн хэрэгжилтийг баталгаажуулахгүй талаар

⁷⁶ Katharine G. Young, *өмнөх эшлэл* 28, 193 дахь тал.

⁷⁷ Katharine G. Young, *өмнөх эшлэл* 28, 200 дахь тал.

⁷⁸ Katharine G. Young, *өмнөх эшлэл* 28, 201 дэх тал.

⁷⁹ Katharine G. Young, *өмнөх эшлэл* 28, 201-202 дахь тал.

тусгасан эсэхийг шалгахаас гадна олон улсын гэрээнд нэгдэн орохдоо тодорхой төрлийн ЭЗНСЭ-ийн хэрэгжилтийг хүлээн зөвшөөрөхгүй талаар мэдэгдэл хийсэн эсэхийг шалгах нь зүйтэй.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр ЭЗНСЭ-ээс ухрах хэлбэрээр эрхийг хязгаарлах тохиолдол байж болно. Энэ тохиолдолд процессын болон агуулгын шалгалтыг хийх нь зүйтэй. Процессын шалгуураар үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг батлахад тавигдах журмын зохицуулалтыг дагаж мөрдсөн эсэхийг үнэлдэг. Харин агуулгын шалгуураар үндсэн хуульд тусгагдсан өөрчлөгдөшгүй заалт (unamendable provision)-ыг өөрчилсөн эсвэл үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалыг (basic structure of the constitution) хөндсөн эсэхийг шалгана.⁸⁰ Өөрөөр хэлбэл үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь ЭЗНСЭ-ийн агуулгаас ухарсан эсэх, үндсэн хуульд өөрчлөгдөшгүй заалт тусгагдсан эсэх, эсвэл Үндсэн хуулийн үндсэн бүтцийн онолын үүднээс нэмэлт, өөрчлөлт хүчинтэй эсэхийг үнэлэх юм.

ЭЗНСЭ-ийг үндсэн хуульд төрийн бодлогын зорилго, зарчмын шинжтэй тусгах хэлбэрээр хязгаарлалт үүснэ. Тухайлбал, Энэтхэг улсын Үндсэн хуулийн 4-р бүлгийг “төрийн бодлогыг чиглүүлэх зарчим” гээд 37-д “Энэ бүлэгт дурдсан заалтын аль нь ч шүүхээр хянагдахгүй, тэдгээрт тусгасан зарчим нь улсын засаглалын суурь бөгөөд хууль тогтоохдоо эдгээр зарчмыг баримтлах нь төрийн үүрэг болно.” гэж заасан. Иймд ЭЗНСЭ-ийн маргааныг хянан шийдвэрлэхдээ төрийн бодлого, зарчмын шинжтэй тусгасан эсэхийг шалгана. Гэхдээ хүний эрх хуваагдашгүй байх зарчмын дагуу тэдгээр эрх ИБУТЭ-ийн хэрэгжилтийн нэг хэсэг байж болох тул ИБУТЭ хөндөгдөж байгаа эсэхийг шалгах нь зүйтэй. Жишээлбэл амьд явах, хүнлэг бус, хэрцгий, доромж хандлагаас ангид байх эрх нь эрүүл мэндээ хамгаалуулах, эд, мөнгөний тусламж авах, сурч боловсрох эрхтэй салшгүй холбоотой. Мөн урьд өмнө шийдвэрлэгдсэн шүүхийн жишгийг (case-law) шалгах хэрэгтэй.

V. Дүгнэлт

Онолын түвшинд төр ЭЗНСЭ-ийг хэрэгжүүлэхэд ямар үүрэгтэй байх, түүнийг ямар хэмжээнд хамгаалах ёстой талаар нийтлэгээр хүлээн зөвшөөрөхүйц зөвшилцөлд хүрээгүй байдаг. Гэсэн хэдий ч ЭЗНСЭ-ийг хэрэгжүүлэх чухал арга хэрэгсэл бол тэдгээр эрхийг хамгаалах шүүхийн үүрэг, цар хүрээг тодорхойлох явдал юм. Тиймээс уг өгүүллээр ЭЗНСЭ-ийн талаарх онолын маргааныг бичихийн

⁸⁰ Тогтохын Эмүжин, “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад тавигдах агуулгын хязгаарлалт - Үндсэн хуулийн цэцийн хяналтын хүрээ”, <https://legaldata.mn/b/1543>, 2022.

зэрэгцээ эрх мэдэл хуваарилах зарчмыг хөндөхгүйгээр шүүх хэрхэн ЭЗНСЭ-ийг хамгаалах нь зүйтэй талаар авч үзлээ. Ингэхдээ ЭЗНСЭ-ийн маргаанд улс төрийн бодлогыг хүндэтгэх зарчим, эрхийн хязгаарлалтын төрөл тус бүрд ямар зарчмыг удирдлага болгох талаар тодорхойлсон. Үүнд (1) ЭЗНСЭ-ийг дэвшилттэйгээр хэрэгжүүлэх үүргээ биелүүлэхгүй байх, эрхийн хэрэгжилтээс ухрах арга хэмжээ авах, хэрэгжилтийг удаашруулах хэлбэрээр хязгаарласан тохиолдолд тухайн эрхийн цөмийг үгүйсгээгүй байх, тэгш байдал, тохирсон байх, үндэслэлтэй байх зарчмыг хэрэглэх; (2) Негатив үүргээ биелүүлэхгүй байх хэлбэрээр хязгаарласан тохиолдолд эрх зүйн тодорхой байдал, тохирсон байх, тэгш байдлын зарчмыг хэрэглэх; (3) бусад аргачлал хамаарна.

[Ном зүй]

Брэнан Жейсон., Либертари үзэл, (Орч. Б. Батчулуун), Улаанбаатар: Непко, 2013 он.

Бяраагийн Чимид., Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс: Ихэс дээдэс, хүн бүрт хандсан дөрвөн өчил, Улаанбаатар, 2006 он.

Вольф Жонатан, Улс төрийн философи, (Орч. Б. Батчулуун), Улаанбаатар: Непко, 2006 он.

Дашбалбарын Гангабаатар ., Үндсэн хуулийн эрх зүйн удиртгал, Улаанбаатар, 2012 он.

Жон Стюарт Милл., Эрх чөлөөний тухай, (Орч. Н. Лхагважав), Улаанбаатар: Монсудар, 2021 он.

Миллер Девид, Улс төрийн гүн ухаан (Товч танилцуулга), (Орч. О. Очиржав), Улаанбаатар: Эрх зүйт ёс сан, 2017 он.

Одонхүүгийн Мөнхсайхан ., Үндсэн хуулийн хяналт ба тайлбар: үндсэн эрх, Улаанбаатар, 2022 он.

Свифт Адам, Улс төрийн философи (3 дахь хэвлэл), (Орч. Б. Батчулуун), Улаанбаатар: Эрх зүйт ёс сан, 2016 он.

Тогтохын Эмүжин ., Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс: Үндсэн хуулийн цэцийн эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн баталгааг хангах чиг үүрэг, цар хүрээ, Улаанбаатар, 2025 он.

Тогтохын., “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад тавигдах агуулгын хязгаарлалт - Үндсэн хуулийн цэцийн хяналтын хүрээ”, <https://legaldata.mn/b/1543> , 2022 он.

Alexy Robert, A Theory of Constitutional Rights, (Trans. Julian Rivers), Oxford: Oxford University Press, 2002.

Benvenisti Eyal, “Margin of Appreciation, Consensus, and Universal Standards”, International Law and Politics, 31, 2000.

Bilchitz David, Poverty and Fundamental Rights: The Justification and Enforcement of Socio-Economic Rights, Oxford: Oxford University Press, 2007 .

Butler Eamonn, Classical Liberalism: A Primer, London: Institute of Economic Affairs, 2015.

Cranston Maurice, “Are There Any Human Rights?”, Daedalus, 112 (4), 1983.

Donnelly Jack, Universal Rights in Theory and Practice (2nd ed.), Ithaca, NY: Cornell University Press, 2003.

Fitzpatrick Tony, After the New Social Democracy: Social Welfare for the Twenty-First Century, Manchester: Manchester University Press, 2003.

Freeden Michael, Sargent Lyman Tower, and Stears Marc (Eds.), The Oxford Handbook of Political Ideologies, Oxford: Oxford University Press, 2013.

Human Rights Committee, CCPR General Comment No. 6: Article 6 (Right to Life), 1982.

- International Commission of Jurists, *Judicial Enforcement of Economic, Social and Cultural Rights*, Geneva, 2014 .
- Kay Boyle., *Economic and Social Rights Law: Incorporation, Justiciability and Principles of Adjudication* (1st ed.), London: Routledge, 2020 .
- Labonte Melissa. and Mills Kurt., *Human Rights and Justice: Philosophical, Economic, and Social Perspectives*, London: Routledge, 2018.
- Langford Malcolm., “Domestic Adjudication and Economic, Social and Cultural Rights: A Socio-Legal Review”, *Social Science Research Network*, 2009.
- Michelmann Frank I., “Reasonable Umbrage: Race and Constitutional Antidiscrimination Law in the United States and South Africa”, *Harvard Law Review*, 117 (5), 2004.
- Möller Kai, “Balancing and the Structure of Constitutional Rights”, *International Journal of Constitutional Law*, 5 (3), 2007.
- Nickel James W., “How Human Rights Generate Duties to Protect and Provide”, *Human Rights Quarterly*, 15 (1), 1993.
- Nolan Aoife, Porter Bruce, and Langford Malcolm, *The Justiciability of Social and Economic Rights: An Updated Appraisal*, CHRGI Working Paper No. 15, 2009.
- Nowak Manfred, *UN Covenant on Civil and Political Rights: CCPR Commentary* (2nd ed.), Kehl am Rhein: N. P. Engel, 2005 .
- O’Neill Onora, “The Dark Side of Human Rights”, *International Affairs*, 81 (2), 2005 .
- Palmer Ellie, *Judicial Review, Socio-Economic Rights and the Human Rights Act*, Oxford: Hart Publishing, 2007 .
- Rawls John, *Justice as Fairness: A Restatement*, Cambridge, MA: Harvard University Press, 2001.
- UN Committee on Economic, Social and Cultural Rights, *General Comment No. 3: The Nature of States Parties’ Obligations*, 1990 .
- Young Katharine G., *Constituting Economic and Social Rights*, Oxford: Oxford University Press, 2012.

[Abstract]

The Theoretical Basis for Protecting Economic, Social, and Cultural Rights in The Constitutional Tests (Court)

Emujin Togtokh

*Bachelor of Laws (LL.B.).
School of Law, National University of Mongolia
Ulaanbaatar, Mongolia*

This article provides a theoretical justification, grounded in political philosophy and human rights theory, for why the Constitutional Court should play a role in protecting economic, social, and cultural rights. It further seeks to identify the principles that should guide such protection without infringing upon the separation of powers, given that the realization of these rights is inextricably linked to the State's resources and policy choices. Clarifying the standards and methodologies applicable to the resolution of disputes concerning these rights is essential for strengthening their protection and ensuring greater coherence in constitutional adjudication. Within this theoretical framework, the analysis considers criteria such as the minimum core of fundamental rights, the principle of equality, the principle of proportionality and others.

[Keywords]

Economic, Social and Cultural rights, Constitutional court, Minimum core, Equality, Proportionality, Separation of powers.